<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>127,324,281.42</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>162,153,791.00</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>6.00</b>	<b>6.00</b>
610001	Төсвийн байгууллага	6.00	6.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>59.00</b>	<b>39.00</b>
620001	Удирдах ажилтан	10.00	10.00
620002	Гүйцэтгэх ажилтан	11.00	11.00
620003	Үйлчлэх ажилтан	34.00	14.00
620004	Гэрээт ажилтан	4.00	4.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>219,340,249.00</b>	<b>57,913,892.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>219,340,249.00</b>	<b>57,913,892.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>194,140,249.00</b>	<b>57,913,892.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>37,887,408.00</b>	<b>-</b>
210101	Үндсэн цалин	37,484,908.00	-
210102	Нэмэгдэл	402,500.00	-
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>4,646,073.00</b>	<b>-</b>
210201	Тэтгэврийн даатгал	4,646,073.00	-
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>14,573,934.00</b>	<b>1,500,000.00</b>
210303	Цэвэр, бохир ус	14,573,934.00	1,500,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>2,742,982.00</b>	<b>1,261,600.00</b>
210401	Бичиг хэрэг	925,382.00	-
210402	Тээвэр, шатахуун	147,200.00	1,211,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	50,000.00
210404	Ном, хэвлэл	1,670,400.00	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>44,793,561.00</b>	<b>-</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	36,973,830.00	-
210502	Хоол, хүнс	7,819,731.00	-
<b>2107</b>	<b>Томилголт, зочны зардал</b>	<b>-</b>	<b>4,104,000.00</b>
210702	Дотоод албан томилголт	-	4,104,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>8,672,100.00</b>	<b>-</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,672,100.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>80,824,191.00</b>	<b>51,048,292.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	76,224,191.00	49,948,292.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,600,000.00	1,100,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>25,200,000.00</b>	<b>-</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>25,200,000.00</b>	<b>-</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	25,200,000.00	-
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>5,302,866.00</b>	<b>2,189,212.00</b>
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	-	2,189,212.00
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	5,302,866.00	-
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>224,775,115.00</b>	<b>59,970,104.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>224,775,115.00</b>	<b>59,970,104.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,895,100.00	-
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	27,366,377.00	20,524,500.00
131104	Дэд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	168,958,433.00	10,052,600.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	22,555,205.00	29,393,004.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)-(I)</b>		<b>(132,000.00)</b>
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		132,000.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	132,000.00	-

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Засаг дарга нь “Шударга, ил тод, сахилга хариуцлагатай төрийн албыг төлөвшүүлэн, мэргэшсэн чадварлаг баг хамт олноор иргэдэд үйлчилж, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулахад оршино” эрхэм зорилгын хүрээнд сумын нийгэм эдийн засгийн чадавхыг дээшлүүлэхэд чиглэсэн оновчтой бодлого, нийгмийн салбарын хөгжлийг ахиулахад дэмжлэг үзүүлэх зорилго, үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзсэн.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

#### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,397.9 сая төгрөгөөр буюу 43.8 хувиар буурсан байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	234.5	499.3	264.8
Авлага	247.9	96.5	-151.4
Бараа материал	308.5	116.2	-192.3
Үндсэн хөрөнгө	3,803.4	1,885.1	-1,918.3
Нийт хөрөнгө	<b>4,594.3</b>	<b>2,597.1</b>	<b>-1,997.2</b>
Өр төлбөр	12.6	0	-12.6

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	4,581.7	2,597.1	-1,984.6
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>4,594.3</b>	<b>2,597.1</b>	<b>-1,997.2</b>

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өсөж, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн үлдэгдэл буурсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 264.8 сая төгрөгөөр өссөн нь орон нутгийн ерөнхий орлогод төлөвлөгдөөгүй шонхор шувууны орлого орсон нь нөлөөлсөн байна.
- Авлагын дансны үлдэгдэл өмнөх оноос 151.4 сая төгрөгөөр буурсан нь Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төвийн бараа материал бүтцийн өөрчлөлтөөр улсын төсөвт шилжүүлсэн, мөн хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн авлагын үлдэгдэл 96.5 сая төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна.
- Бараа материал, үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл буурахад Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төвийн үндсэн хөрөнгийг бүтцийн өөрчлөлтөөр улсын төсөвт шилжүүлж, дээд шатын төсөв захирагчид санхүүгийн тайланг нэгтгүүлсэн нь нөлөөлсөн байна.

### **3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт**

#### **3.5.1 Мөнгөн хөрөнгө**

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 479.0 сая төгрөг болж, өмнөх оноос 319.1 сая төгрөгөөр буурсан байна.

#### *Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	234.5	499.3	264.8
Төгрөг	234.5	499.3	264.8
Төрийн сангийн харилцах	233.2	499.3	266.1
Арилжааны банк дахь харилцах	1.2	0.02	-1.3
Нэмэлт санхүүжилтийн харилцах	0.1	-	
<b>Дүн</b>	<b>234.5</b>	<b>499.3</b>	<b>264.8</b>

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 499.3 сая төгрөг төрийн сангийн харилцах дансанд, 0.02 сая төгрөг байгууллагын арилжааны банкны харилцах дансанд байршиж байна.

Мөнгөн хөрөнгийн харилцах дансны үлдэгдлийн 108.4 сая төгрөг буюу 21.7 хувийг хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт, хүүгийн орлого, 53.8 сая төгрөг буюу 10.8 хувийг ОНХС-ийн төсөл арга хэмжээний санхүүжилт, 337.1 сая төгрөг буюу 67.5 хувь төрийн сангийн харилцахын оны эхний зарцуулагдаагүй үлдэгдэл тус тус эзэлж байна.

#### **Аудитын илрүүлэлт**

- Тайлант онд барилгын ажил гүйцэтгэх ажил хэрэгжүүлсэн боловч захиалагчийн болон зохиогчийн хяналт хэрэгжээгүй байна. /ОНХС/
- Бараа худалдан авах төсөл арга хэмжээний төсөвт өртгийн тооцоо, судалгаа нь найдвартай, үндэслэлтэй байх шаардлагад нийцэхгүй байна. /ОНХС/
- Сахилгын шийтгэлтэй ажилтанд үр дүнгийн урамшуулал 180.9 мянган төгрөгийг олгож, төсвийг илүү зарцуулсан. /ЗДТГ/
- Албан томилолтыг удирдамж боловсруулаагүй төсөв захирагчийн тушаал шийдвэргүйгээр олгосон./ЗДТГ, ИТХ/
- Нягтлан бодогчийг ТҮ-8 зэрэглэлээр цалинжуулаагүй. /ЗДТГ/

- Ажлын зураг, төсөвгүй болон зураг, төсөв нь магадлалаар баталгаажуулаагүй төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна. /ОНХС/
- Сумын 2023 оны төсөвт хувийн өмчлөлд шилжих болон хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр урамшуулал олгох 40,000.0 мянган төгрөгийн төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна./ОНХС/
- Өөрт хамааралгүй 1,062.0 мянган төгрөгийн хэвлэл захиалга хийсэн./ИТХ/
- Цахим дэлгүүрт байршсан хөрөнгийг худалдан авалгүйгээр бусад этгээдээс 4,000.0 мянган төгрөгийн худалдан авсан./ИТХ/

### 3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 247.9 сая төгрөг болж, өмнөх оноос 151.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага		0.9	0.9
Төлбөртэй үйлчилгээний авлага	45.2	-	-45.2
Байгууллагаас авах авлага	9.6	-	-9.6
Хувь хүмүүсээс авах авлага	193.1	95.6	-97.5
<b>Дүн</b>	<b>247.9</b>	<b>96.5</b>	<b>-151.4</b>

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд хоршоо хөгжүүлэх сангаас олгосон зээл, зээлийн хүүгийн авлага 96.5 сая, хүн амын орлогын албан татварыг илүү шилжүүлсэн 0.9 сая төгрөг байна.

### Аудитын илрүүлэлт

- Зээлийн гэрээний хугацаа дууссан боловч хариуцагч нас барсантай холбоотойгоор 4,160.9 мянган төгрөгийн зээлийг төлж барагдуулаагүй байна. /ХХС/
- Зээлийн барьцааны гэрээг /үл хөдлөх хөрөнгө барьцаалсан тохиолдолд/ хуульд заасны дагуу улсын бүртгэлд бүртгүүлж, баталгаажуулаагүй. /ХХС/
- Цалингийн зардлаас Татварын хэлтэс рүү 1,141.2 мянган төгрөгийн хаоат-ыг илүү шилжүүлж авлага үүсгэсэн. /ЗДТГ/

### 3.5.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 116.2 сая төгрөг болж, өмнөх оноос 192.2 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	21.5	1.8	-19.7
Тусгай зориулалттай материал	5.5	-	-5.5
Эм боох материал	16.0	1.8	-14.2
Хангамжийн материал	210.0	39.1	-170.9
Бичиг хэргийн материал	7.4	0.6	-6.8
Аж ахуйн материал	153.3	24.9	-128.4
Сэлбэг хэрэгсэл	7.0		-7.0
Түлш, шатах тослох материал	3.3		-3.3
Хүнсний материал	3.2		-3.2
Бусад хангамжийн материал	35.8	13.6	-22.2
Мал амьтад	76.9	75.3	-1.6
<b>Дүн</b>	<b>308.4</b>	<b>116.2</b>	<b>-192.2</b>

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны 116.2 сая төгрөгийн үлдэгдлийн 64.8 хувийг мал амьтад, 33.6 хувийг хангамжийн материал эзэлж байна. Хангамжийн материалд аж ахуйн материалын үлдэгдэл гол нөлөөлж байна. Аж ахуйн материалын 95.5 хувийг Засаг даргын Тамгын

газар, 4.0 хувийг иргэдийн Төлөөлөгчдийн хурал, 0.5 хувийг эргэлтийн эмийн сан зэрэг байгууллагууд эзэлж байна.

### 3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 1,885.4 сая төгрөг болж, өмнөх оноос 1,918.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	3,759.2	1,877.4	-1,881.8
Барилга, байгууламж, орон сууц	3,328.3	1,608.3	-1,720.0
Хуримтлагдсан элэгдэл	(463.6)	(371.0)	92.6
Авто-тээврийн хэрэгсэл	187.4	153.9	-33.5
Хуримтлагдсан элэгдэл	(87.8)	(89.4)	-1.6
Машин тоног төхөөрөмж (компьютер)	584.5	182.7	-401.8
Хуримтлагдсан элэгдэл	(377.2)	(118.9)	-258.3
Тавилга, аж ахуйн эд хогшил	206.9	53.6	-153.3
Хуримтлагдсан элэгдэл	(136.2)	(37.9)	98.3
Бусад үндсэн хөрөнгө	790.9	741.2	-49.7
Хуримтлагдсан элэгдэл	(292.6)	(244.9)	-47.7
Ном	18.6	-	-18.6
Биет бус хөрөнгө	44.2	7.7	-36.5
Програм хангамж	1.6	4.2	2.6
Хуримтлагдсан элэгдэл	(1.6)	(0.7)	0.9
Бусад биет бус хөрөнгө	44.2	4.2	-40.0
<b>Дүн</b>	<b>3,803.4</b>	<b>1,885.1</b>	<b>-1,918.3</b>

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 21.0 сая, үнэ төлбөргүй 220.0 сая, бусад 138.3 сая нийт 379.3 сая төгрөгөөр нэмэгдэж, Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төвийн үндсэн хөрөнгийг бүтцийн өөрчлөлтөөр улсын төсөвт шилжүүлж, дээд шатын төсөв захирагчид нэгтгүүлсэн 2,793.6 сая төгрөг, нийт 1,918.3 сая төгрөгөөр буурсан байна.

#### Аудитын илрүүлэлт

- ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон барилга байгууламжийг данс бүртгэлд тусгах шийдвэрт зураг төсвийн зардлыг тухайн барилга байгууламжийн өртөгт оруулаагүй, бараа материалд бүртгэсэн байна. /ОНХС/

### 3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөр тайлант онд 12.6 сая төгрөгөөр буурч үлдэгдэлгүй байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өглөг	2.0	-	-2.0
Байгууллагад төлөх өглөг	10.6	-	-10.6
<b>Дүн</b>	<b>12.6</b>	<b>-</b>	<b>-12.6</b>

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд 12.6 сая төгрөгийн өр төлбөрийг барагдуулж өр төлбөргүй болсон байна.

#### Аудитын илрүүлэлт

- Тайлант онд төсөл арга хэмжээний гүйцэтгэгч компанид санхүүжилт дутуу олгосонтой холбоотой 9,400.0 мянган төгрөгийн өглөгийг санхүүгийн тайланд тусгаагүй байна. / ОНХС/

### 3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 2,597.2 сая төгрөг болж, өмнөх оноос 1,997.1 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

/ сая төгрөгөөр/

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,355.5	393.1	-962.4
Өмч /төрийн/ / хувийн/	1,351.9	389.5	-962.4
	3.6	3.6	-
Хуримтлагдсан үр дүн	1,814.4	2065.0	250.6
Өмнөх үеийн үр дүн	1,278.9	3,997.7	2,718.8
Тайлант үеийн үр дүн	535.5	-1,932.7	-1,397.2
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,411.7	138.9	1,272.8
<b>Дүн</b>	<b>4,594.3</b>	<b>2,597.2</b>	<b>-1,997.1</b>

Цэвэр хөрөнгийн дүн 2,597.1 сая төгрөг болж 1,997.1 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төвийн бүтцийн өөрчлөлтөөр улсын төсөвт шилжүүлж, дээд шатын төсөв захирагч нэгтгэл хийгдсэнээс засгийн газрын оруулсан капитал 962.4 сая, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү 1,272.8 сая, хуримтлагдсан үр дүн 250.6 сая нийт 3,892.9 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын залруулга хийж, тайлант үед 1,932.7 сая төгрөгийн үр дүнгүй ажилласан нь нөлөөлсөн байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 5 дугаар сарын 31-ны өдрийн 04 дугаар тогтоолоор сумын төсвийн татварын орлого 348.9 сая төгрөг, татварын бус орлого 350.0 сая нийт 689.9 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр татварын орлого 487.8 сая, татварын бус орлого 110.2 сая нийт 598.0 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, гүйцэтгэл 14.5 хувиар тасарсан байна.

Хүснэгт 10 Орлогын биелэлт

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өссөн /Буурсан/
<b>НИЙТ ОРЛОГО</b>	<b>698.9</b>	<b>598.0</b>	<b>-100.9</b>
<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>348.9</b>	<b>487.8</b>	<b>138.9</b>
<b>Хувь хүний орлогын албан татвар</b>	<b>185.5</b>	<b>228.8</b>	<b>43.3</b>
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал болон түүнтэй адилтгах орлогын албан татвар	139.0	185.0	46.0
Үйл ажиллагааны орлого	12.5	10.4	-2.1
Хөрөнгийн орлого	31.0	27.5	-3.5
Шууд бус орлого		1.3	1.3
Хөрөнгө борлуулсны орлого	3.0	4.6	1.6
Хөрөнгийн албан татвар	<b>80.0</b>	<b>74.8</b>	<b>-5.2</b>
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	28.5	31.4	2.9
Бууны албан татвар	1.5	0.9	-0.6
Малд ногдуулах албан татвар	50.0	42.5	-7.5
Бусад татвар (төлбөр, хураамж)	<b>6.1</b>	<b>4.8</b>	<b>-1.3</b>
Улсын тэмдэгтийн хураамж	1.5	2.7	1.2

Хог хаягдлын үйлчилгээний хураамж	1.5	1.5	0.0
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	2.5	0.6	-1.9
Ус рашаан, ашигласны төлбөр	0.6		-0.6
Газрын төлбөр	41.0	16.7	-24.3
Газрын төлбөр	41.0	16.7	-24.3
Байгалийн нөөц ашигласны төлбөр	36.3	162.7	126.4
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	36.3	162.7	126.4
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>350.0</b>	<b>110.2</b>	<b>-239.8</b>
Хүү, торгуулийн орлого	60.0	60.1	0.1
Нэр заагдаагүй орлого	290.0	50.1	-239.9

Орон нутгийн татварын болон татварын бус орлого нийт дүнгээрээ төлөвлөснөөс 100.9 сая төгрөгөөр тасарсан байна. Байгалийн нөөц ашигласны төлбөр 126.4 сая төгрөгөөр давсан нь төлөвлөгдөөгүй ан амьтны нөөц ашигласны төлбөр төвлөрсөн нь нөлөөлжээ. Цалин түүнтэй адилтгах орлого 46.0 сая төгрөгөөр давсан нь Засгийн газрын 2022 оны 192 дугаар тогтоолоор цалин нэмэгдсэнтэй холбоотой байна.

### Аудитын илрүүлэлт

- Малын тоо толгойн албан татвар 31,340.0 мянган төгрөгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн /Засаг дарга/

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,264.5 сая төгрөг, нийт зардлыг 1,264.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Сумын 2022 оны төсөвт тусгай зориулалтын байгууллагын тогтмол зардал 256.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 1,520.5 сая төгрөгөөр баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд Засаг даргын хэрэгжүүлэх 7 хөтөлбөрт зориулан 1,520.5 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 998.7 сая төгрөгийг урсгал зардалд, 491.8 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 30.0 сая төгрөгийг хоршоо хөгжүүлэх сангаас олгох зээлд зарцуулахаар батлагджээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 928.0 сая, ОНХС-д олгох орлогын шилжүүлэг 299.4 сая, туслах үйл ажиллагааны орлогоос 97.4 сая нийт 1,324.8 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,280.5 сая төгрөг буюу 96.6 хувьтай байна.

Хүснэгт 11. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/сая төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
<b>70105 Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага</b>					
1	80101-Үндсэн үйл ажиллагаа	85.2	79.4	5.8	94%
2	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	45.2	32.7	12.5	72%
3	82201-Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	3.0	3.0	0.0	100%
	<b>Дүн</b>	<b>133.4</b>	<b>115.1</b>	<b>17.3</b>	
<b>70106 Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага</b>					
1	80101-Үндсэн үйл ажиллагаа	336.1	308.9	18.2	94%
2	80106- Баг хорооны үндсэн үйл ажиллагаа	59.0	51.4	7.6	87%
3	80714-Ахмад настнуудад үзүүлэх хөнгөлөлт	8.2	8.2	-	100%
4	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	13.9	13.4	0.5	96%
5	81102-Орон нутгийн нөөц хөрөнгө	40.0	39.9	0.1	100%
6	81518-Мөрийн хөтөлбөрт тусгагдсан зардал	40.0	40.0	-	100%
7	81549- Ахмадын сан	1.5	1.4	0.1	93%
8	81701- Байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардал	13.5	13.0	0.5	93%
9	82310- Гамшгаас сэргийлэх сургалт, сурталчилгаа	7.0	7.0	-	100%
10	83201 -Ангилалдаагүй бусад зориулалт арга хэмжээ	5.0	4.9	0.1	98%
	<b>Дүн</b>	<b>524.2</b>	<b>488.1</b>	<b>27.1</b>	
<b>71602 Эмнэлгийн тусламж үйлчилгээ</b>					
1	80111-Төрийн өмчийн байгууллагын тогтмол зардал	25.6	23.8	1.8	93%
	<b>Дүн</b>	<b>25.6</b>	<b>23.8</b>	<b>1.8</b>	
<b>71802 Ерөнхий боловсрол</b>					
1	80111-Төрийн өмчийн байгууллагын тогтмол зардал	124.8	87.5	37.3	70%
2	80112-Нийтлэг үйлчилгээ	52.5	46.8	5.7	89%

Дүн		177.3	134.3	43	
71801 Сургуулийн өмнөх боловсрол					
1	80111-Төрийн өмчийн байгууллагын тогтмол зардал	43.0	41.3	1.7	96%
2	80112-Нийтлэг үйлчилгээ	26.1	24.4	1.7	93%
Дүн		69.1	65.7	3.4	
71702 Соёл урлаг					
1	80111-Төрийн өмчийн байгууллагын тогтмол зардал	40.4	31.5	8.9	78%
2	80112-Нийтлэг үйлчилгээ	6.9	6.9	0	100%
Дүн		47.3	38.4	8.9	
70106 Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага					
1	83401-Итгэлцүүрээр	260.5	240.5	20.0	92%
2	83405-Малын тоо толгойн албан татвар	70.8	32.8	38.0	46%
3	83406-ОНХС-бусад	160.5	120.5	40.0	75%
Дүн		491.8	393.8	98.0	
72101 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих					
1	82611-Жижиг дунд үйлдвэрлэл дэмжих		96.8	-96.8	
2	83111-Сум хөгжүүлэх	30.0		30	
Дүн		30.0	96.8	-66.8	322%
Нийт дүн		1,520.2	1,356.00	132.70	

Орон нутгийн төсвийн орлого тасарсантай холбоотой орон нутгийн хөгжлийн санд тусгасан зарим арга хэмжээг хэрэгжүүлэх зардлууд дутуу санхүүжигдсэн байна.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

ЗДНХ, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 20.5 сая, дээд шатны төсвийн захирагчаас 10.1 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 29.4 сая нийт 60.0 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 1.5 сая, хангамж, бараа материалын зардалд 1.3 сая, томилолт, зочны зардалд 4.1 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 51.0 сая, нийт 57.9 сая төгрөгийг зарцуулж үлдэгдэл 2.1 сая төгрөгийг төрийн сангийн дансанд төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Уулбаян сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2023 оны 3 дугаар сарын 15 -аас 2023 оны 3 дугаар сарын 25 -ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2023 оны 3 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Засаг даргад хүргүүлэхээр төлөвлөн, Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор М.Нарантуяа, аудитын менежер Г.Даваа нар үе шатны хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Н.Болдбаатар гүйцэтгэв.

Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 01/09 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт 1,933.5 сая төгрөгийн зардлын 1.5 хувь буюу 29.0 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Уулбаян сумын Засаг даргын тухай хуульд хамаарах зүйл заалт бүрээр горим сорил хэрэгжүүлсэн.

##### Аудитын илрүүлэлт

- *Ажлын зураг, төсөвгүй болон зураг, төсөв нь магадлалаар баталгаажгаагүй төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна. /ОНХС/*
- *Сумын 2023 оны төсөвт хувийн өмчлөлд шилжих болон хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр урамшуулал олгох 40,000.0 мянган төгрөгийн төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна./ОНХС/*
- *Өөрт хамааралгүй 1,062.0 мянган төгрөгийн хэвлэл захиалга хийсэн./ИТХ/*
- *Цахим дэлгүүрт байршсан хөрөнгийг худалдан авалгүйгээр бусад этгээдээс 4,000.0 мянган төгрөгийн худалдан авсан./ИТХ/*

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд тайлант онд гарсан өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой гаргасан тушаал шийдвэр, орлого зарлагын мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулсан байна.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай болон бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

## 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Сүхбаатар аймгийн Уулбаян сумын төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн талаар бичнэ.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	-	1	-	-	-	100
Зөвлөмж	1	5.3	1	5.3	-	-	100
Нийт	2	5.3	2	5.3	-	-	100

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 31.3 сая төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс 31.3 сая төгрөгийн зөвлөмж өгсөн.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **Орлоготой холбоотой асуудал**

##### 5.3.1 Илрүүлэлт:

Малын тоо толгойн албан татвар 31.3 сая төгрөгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн нь Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 /Албан татвар төлөгчийн өмчилж буй Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа малын тоо толгойд албан татвар ногдуулна/, 5.2 /Тухайн татварын жилд албан татвар ногдуулах малын тоо толгойг Статистикийн тухай хуульд заасны дагуу хийгдсэн өмнөх жилийн мал тооллогын дүнд үндэслэн тодорхойлно./, 6 дугаар зүйлийн 6.2 /Албан татварын хэмжээг энэ хуулийн 6.1-д заасан хязгаарт багтаан сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал малын төрөл тус бүрээр тогтооно/, 7 дугаар зүйлийн 7.1 /Албан татвар төлөгч энэ хуулийн дагуу ногдуулсан албан татварыг тэнцүү хоёр хуваан тухайн жилийн 7 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор өөрийн өмчилж байгаа малын тоо толгой тоологдож бүртгэгдсэн сум, дүүргийн төсөвт төлнө/, Төсвийн тухай хуулийн 41 дугаар зүйлийн 41.2.1 /хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх/, тус тус зөрчсөн байна.

##### Өгсөн зөвлөмж:

Малын тоо толгойн албан татварыг төвлөрүүлэх чиглэлээр Багийн засаг дарга, татварын байцаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тодорхой арга хэмжээ болгон тусгаж, биелэлтийг хангуулах, мөн уг албан татвараар төвлөрсөн хөрөнгийг буцаан малчдад үйлчилгээ үзүүлэх тохиолдолд татвар төлсөн байдлыг шалгуур үзүүлэлт болгон авч үзэхийг зөвлөж байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Засаг даргын тамгын газар	3	0.2	1	0.2	-	-	2	-				
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	2	1.1	1	1.1	-	-	1	-				
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>1.3</b>	<b>2</b>	<b>1.3</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>3</b>	<b>-</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>								
Засаг даргын тамгын газар	1	-	-	-	1	-	-	-
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	1	-	-	-	1	-	-	-
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>								
Орон нутгийн хөгжлийн сан	2	40.0	-	-	2	40.0	-	-
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>40.0</b>			<b>2</b>	<b>40.0</b>		